



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 544

Улаанбаатар хот

“Гонир” ХК-ийн үнэт цаасны өмчлөх эрхийг
шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн “Гонир” ХК-ийн үнэт цаасны арилжааг Хорооны шийдвэрээр зогсоосон байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Гонир” ХК-ийн зарим хувьцаа эзэмшигч Н.Мөнхцэцэг, М.Батсайхан, А.Ариунболд нар нь өөрсдийн өмчлөл дэх нийт 160,332 /нэг зуун жаран мянга гурван зуун гучин хоёр/ ширхэг “Гонир” ХК-ийн энгийн хувьцааг иргэн Б.Батхүүд тус тус шилжүүлэхээр гаргасан хүсэлт, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан гэрээний дагуу өмчлөх эрхийг холбогдох журмаар тогтоосон нөхцөл, шаардлага, нотлох баримтын бүрдэл, үйлчилгээний хөлсийг авах журмын дагуу гүйцэтгэх, үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулахыг “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Гонир” ХК-ийн хяналтын багцыг өмчлөх болсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг иргэн Б.Батхүүд үүрэг болгосугай.


1/ Компанийн тухай хуулийн 59.4-т заасны дагуу хувьцаат компанийн ээлжит хурлыг хуралдуулж, компанийн удирдлагыг сонгон, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлан, компанийн цаашдын үйл ажиллагааны талаар хувьцаа эзэмшигчдэд тайлагнаж хурлын материалыг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах;

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000874